



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМ

### ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

2016 оны 05 сарын 15-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

#### **”Төлбөр хураах цэг” /Автозамын сан/-ийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалт хийсэн тухай**

##### **Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл**

Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргад 2016 онд нийлүүлэх ажил үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн, Зам, тээврийн сайдын баталсан удирдамжийн хүрээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар тодорхойлогдсон “Төлбөр хураах цэг”/Авто замын сан/-ийн 2014-2015 онд улсын авто замын санд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, Төлбөр хураах цэгүүдийн үйл ажиллагаа, сангийн хөрөнгийн давсан орлогоос санхүүжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэнд санхүүгийн хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох байгуулага, албан тушаалтаныг үнэн зөв мэдээллээр хангахад энэхүү хяналт, шалгалтын зорилго оршино.

##### **Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа**

Хяналт, шалгалтыг Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн, санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагч Л.Оюунбилэг, ахлах мэргэжилтэн, санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч Н.Оюунбилэг нар 2016 оны 4 дүгээр сарын 25-ний өдрөөс эхлэн ажлын 18 хоногт хийж гүйцэтгэлээ.

##### **Гурав. Шалгагдсан байгууллагын үйл ажиллагаа, эрх зүй**

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын зорилго нь: “Хэрэглэгчээ дээдэлж, хүний хөгжил, дэвшилтэт технологид түшиглэн үр ашигтай үйлчилгээ үзүүлэх” гэж тодорхойлогдсон байна.

Төлбөр хураах цэг /Замын сан/ нь Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т харьяалагддаг регистр РД-5645913-тэй.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд “Авто замын сан”-гийн үйл ажиллагааг тусгайлсан хуулиар зохицуулахаар заасны дагуу Авто замын тухай хуулиар зохицуулагддаг байна.

Төлбөр хураах цэг нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Авто замын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын

тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Журам батлах тухай” 106 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын 2015 оны “Төлбөр хураах цэгийн үйл ажиллагаанд мөрдөх журам” зэрэг эрх зүйн баримт бичиг, холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа дагаж мөрддөг байна.

### **Дөрөв. Шалгалтын явц, шалгалтанд хамрагдсан асуудал**

Шалгалтаар тус Төлбөр хураах цэг /ТХЦ/-ийн 2014 он, 2015 оны мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын баримт, цалин хөлсний болон үндсэн хөрөнгө, бараа материал, төсвийн мэдээ, тайлан тэнцлийн гаргалт, үнэт цаасны тооцоо, түүний нууцлал, хадгалалт хамгаалалт, төвийн захирлын гэрээт ажилтнуудтай байгуулсан “Хөлсөөр ажиллах гэрээ”, ТХЦ-тэй холбогдуулан төвийн захирлын гаргасан тушаал, шийдвэр болон замын сангийн давсан орлогоос санхүүжүүлэн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн биелэлт, үр дүн, бусад байгууллага хүмүүстэй хийсэн гэрээ хэлэлцээр болон холбогдох бусад баримтыг хамруулан шалгав.

4.1 ТХЦ нь 15 төлбөр хураах цэгээр дамжуулан олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зохих хураамжийг авч улсын төсөвт төвлөрүүлэн ажилладаг байна. Төлбөр хураах цэг /Замын сан/ нь “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т харьяалагддаг боловч төсөвт байгууллага тул Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөн Төрийн сан банкны 900028054 тоот дансаар орлого, зардлын гүйлгээг хийж ирсэн байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн төвийн захирал Төлбөр хураах цэг /Авто замын сан/-ийн төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Хяналт шалгалтанд хамрагдсан хугацаанд төсөв захирагчийн эрхийн гарын үсгийн нэгдүгээрийг 2014.01.01-нээс 2015.01.16-ныг хүртэл “АЗХЭШСТ” УТҮГ-ын захирал Р.Отгонбаатар, 2015.01.16-наас 2015.10.08 хүртэл захирал Б.Наранбат, 2015.10.08-наас өнөөг хүртэл захирал Б.Мандат нар, гарын үсгийн хоёрдугаарыг 2014.01.01-ээс 2015.03.30 хүртэл “АЗХЭШСТ” УТҮГ-ын Төлбөртэй зам хариуцсан санхүү бүртгэлийн мэргэжилтэн Л.Чимгээ, 2015.04.01-нээс 2015.12.31 хүртэл “ЗТХТ” ТӨҮГ-ын санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Даваабаатар нар тус тус зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж ирсэн байна.

Харин авто замын сангийн давсан орлогоос санхүүжүүлэн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалтын төсвийн эрх захирагчийн гарын үсгийн нэгдүгээрийг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ, гарын үсгийн хоёрдугаарыг ерөнхий нягтлан бодогч Ч.Ренчиндамба нар зурж зарцуулж ирсэн байна.

4.2. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт: “Дөлгөөн хайрхан уул аудит” ХХК-иас тус “Төлбөр хураах цэг”-ийн 2014.01.01.-нээс эхлэж 2014.12.31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд аудит хийж санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсын хувьд үнэн зөв шударга илэрхийлэгдсэн гээд **“Зөрчилгүй санал, дүгнэлт”** өгч зөвлөмж өгөөгүй байна.

Харин 2015.01.01-нээс эхлэж 2015.12.31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд Юнистар-Аудит ХХК гэрээний дагуу аудит хийж материаллаг зүйлсын хувьд үнэн зөв шударга илэрхийлэгдсэн гээд **“Зөрчилгүй санал, дүгнэлт”** өгч 2 зөвлөмж хүргүүлсний хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

**4.3 Шилэн дансны талаар:** 2015 онд шилэн дансны цахим хуудаст “Замын сан” гэсэн шилэн данс тусдаа нээгээгүй тул ЗТХТ-ийн шилэн дансны мэдээлэлд давхар мэдээлж явсан байна. Мөн ЗТХТ-ийн цахим хуудас дээр “Төлбөр хураах цэг” дэд цонх нээж, төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлт, тендертэй холбоотой мэдээллүүдийг оруулсан байв.

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар шилэн дансны шинэчлэгдсэн цахим хуудас дээр Замын сан /төлбөр хураах цэг/ гэсэн бие даасан байдлаар нээсэн боловч програмын алдаа өгч мэдээлэл шивэх боломжгүй байсан тул Сангийн яаманд удаа дараа хүсэлт гаргасан боловч одоогоор програмыг засагдаагүй байна. Иймд ЗТЯ-аас өгсөн чиглэлийн дагуу ТХЦ-ийн орлого, урсгал зардлын мэдээг ТЕЗ-ийн шилэн дансны Засгийн газрын тусгай сангийн мэдээлэлд сар бүр оруулан ажилласан байна.

#### **Тав. Авто замын сангийн орлого төвлөрүүлэлт, батлагдсан төсвийн зарцуулалт**

**5.1 Орлого төвлөрүүлэлтийн эрх зүйн үндэс:** Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д зааснаар Улсын авто замын сан нь дараахь эх үүсвэрээс бүрддэг гэж заасан. Үүнд:

1. авто бензин, дизелийн түлшний албан татвар;
2. авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;
3. хууль тогтоомжид заасны дагуу авто зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс авах төлбөр;
4. энэ хуулийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль;
5. зээл, тусламж, хандивын орлого;
6. улсын төсвөөс олгосон хөрөнгө;
7. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын авто тээврийн хэрэгслээс авах хураамж;
8. Бусад гэсэн эх үүсвэрүүдээс бүрддэг.

Монгол Улсын Авто замын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Улсын авто замын сан нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, орон нутгийн авто замын сан нь аймаг, нийслэлийн Засаг даргын мэдэлд байна” гэж заасан боловч Зам, тээврийн яамны харьяа байгууллага “хууль тогтоомжид заасны дагуу авто зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс авах төлбөр”-ийг ТХЦ-үүдээр дамжуулан хурааж Авто замын санд 100 хувь төвлөрүүлж захиран зарцуулах эрх нь Сангийн яамаар дамжигдан зарцуулагддаг байна.

#### **5.2. Орлого төвлөрүүлэлт:**

ТХЦ-ийн үндсэн орлого, үйл ажиллагаа нь олон улсын болон улсын чанартай авто зам ашигласны төлбөр хураамжийг нийт 15 ТХЦ-үүдээр дамжуулан авто замын санд төвлөрүүлэх

ажиллагаа юм. Авто замын санд төвлөрүүлэх жилийн орлогын төлөвлөгөөг “Зам,тээврийн хөгжлийн төв” /”ЗТХТ”/ ТӨҮГ-ын захирлын тушаалаар 15 ТХЦ-т хуваарилан гүйцэтгэлийг хангуулах ажлыг “ЗТХТ” ТӨҮГ-ын бүтэцэд байх “Төлбөртэй замын алба” хариуцан гүйцэтгэж ирсэн байна.

*ТХЦ-үүдэд хуваарилсан орлогын төлөвлөгөө  
гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал*

Үзүүлэлт	2014 он			2015 он		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
Рашаант ТХЦ	337,000,000	421,643,700	84,643,700	410,000,000	470,374,300	60,374,300
Налайх-Тэрэлж	200,000,000	305,371,700	105,371,700	290,000,000	288,015,000	(1,985,000)
Замын-Үүд	350,000,000	505,125,800	155,125,800	490,000,000	496,214,000	6,214,000
Хоолтын	242,000,000	342,637,933	100,637,933	330,000,000	311,471,100	(18,528,900)
Өлзийт хороолол	80,000,000	136,728,161	56,728,161	120,000,000	156,953,400	36,953,400
Онгийн гүүр	100,000,000	124,840,500	24,840,500	110,000,000	109,250,700	(749,300)
Хархорин-Хужирт	70,000,000	72,664,400	2,664,400	70,000,000	112,281,000	42,281,000
Дархан	240,000,000	270,039,400	30,039,400	260,000,000	299,263,200	39,263,200
Дулаанхааны	130,000,000	152,766,500	22,766,500	140,000,000	187,297,420	47,297,420
Гурт	28,000,000	31,340,600	3,340,600	30,000,000	69,773,300	39,773,300
Ганц модны	105,000,000	115,410,400	10,410,400	100,000,000	114,883,600	14,883,600
Улаангом	35,000,000	39,848,000	4,848,000	40,000,000	40,131,500	131,500
Түйн гүүр	45,000,000	51,505,800	6,505,800	50,000,000	40,430,800	(9,569,200)
Багануур-Хэрлэн	110,000,000	108,354,000	(1,646,000)	90,000,000	111,513,040	21,513,040
Хангалын гүүр	200,000,000	218,235,600	18,235,600	200,000,000	246,252,000	46,252,000
Цанын бааз	78,000,000		(78,000,000)	170,000,000		(170,000,000)
Бусад		4,963,120			3,717,200	3,717,200
<b>ДҮН</b>	<b>2,350,000,000</b>	<b>2,901,475,614</b>	<b>551,475,614</b>	<b>2,900,000,000</b>	<b>3,057,821,560</b>	<b>157,821,560</b>

ТХЦ-үүд 2014 онд улсын авто замын санд 2,350.0 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 2,901.5 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 23 хувиар буюу 551.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Хамгийн сайн орлого төвлүүлж төлөвлөгөөг давуулсан нь Замын-Үүдэн ТХЦ 155.1 сая төгрөг буюу 44.3 хувиар, Налайх-Тэрэлжийн гүүрийн ТХЦ 105.4 сая төгрөг буюу 52.7 хувиар, Хоолтын ТХЦ 100.6 сая төгрөг буюу 41.6 хувиар, бусад ТХЦ-үүд 2.7-84.6 сая төгрөгөөр тус тус орлогоо давуулан биелүүлсэн байна.

Харин Цанын баазын ТХЦ-ээс төвлөрүүлэх орлого 100% тасарсан бол Багануур-Хэрлэнгийн гүүрийн ТХЦ-ээс оруулах орлогын төлөвлөгөө 1,646.0 мянган төгрөгөөр буюу 1,5 хувиар тасарсан байна.

2015 онд улсын авто замын санд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 2,900.0 сая төгрөг буюу өмнөх оноос 550.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, гүйцэтгэлээр 3,057.8 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 7.4 хувь буюу 157.8 сая төгрөгөөр, өмнөх оны гүйцэтгэлээс 156.4 сая төгрөгөөр буюу 5.4 хувиар илүү төвлөрүүлэн ажилласан байна. Үүнд: Рашаантын ТХЦ 60.3 сая төгрөгөөр буюу 14.7 хувиар, Дулаанхааны ТХЦ 47.3 сая төгрөгөөр, Хангалын гүүрийн ТХЦ 46.2 сая төгрөгөөр, Хархорин-Хужиртын ТХЦ 42.3 сая төгрөгөөр, Дарханы ТХЦ 39.3 сая төгрөгөөр, Гуртын гүүрийн ТХЦ 39.8 сая төгрөгөөр, Өлзийт хоррооллын ТХЦ 36.9 сая төгрөгөөр, Багануур-Хэрлэнгийн гүүрийн ТХЦ 21.5 сая төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс илүү төвлөрүүлсэн байна.

Харин Цаны баазын ТХЦ ажиллаагүйн улмаас 2014 онд 78.0 сая төгрөгийн орлого хуваарилснаас нэг ч төгрөг төвлөрүүлээгүй байхад 2015 онд өмнөх оноос нэмэгдүүлэн 170.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө хуваарилж дахин биелэгдээгүй дүнтэй гарсан байна.

Мөн Хоолтын ТХЦ-ийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 88,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан боловч орлогын төлөвлөгөөг 18.5 сая төгрөгөөр буюу 5.5 хувь тасалдуулсан нь, өмнөх оны гүйцэтгэлээс 31.2 сая төгрөг буюу 9.1 хувиар, Түйн гүүрийн ТХЦ 2015 онд төлөвлөсөн орлогыг 9.6 сая төгрөгөөр буюу 19.1 хувиар тасалж, өмнөх оноос орлого нь 11.1 сая төгрөгөөр буюу 21.5 хувиар, Налайх-Тэрэлжийн гүүрийн ТХЦ-ийн орлогын төлөвлөгөө 0,7 хувь буюу 1.98 сая төгрөгөөр тасарч, өмнөх оноос 17.4 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зам, тээврийн сайдын 2014 оны 109-р тушаалаар “Авто пүү ажиллуулах журам” батлагдснаар Хоолтын ТХЦ, Өлзийт хорооллын ТХЦ, Багануур-Хэрлэнгийн гүүрийн ТХЦ, Замын-Үүдийн ТХЦ-дийн дэргэд суурин авто пүү байршуулан 2014 оны 8-р сараас үйл ажиллагааг нь эхлүүлсэн байна.

Зам, тээврийн сайдын 2015 оны 180 дугаар тушаалаар давсан орлогоос санхүүжин шинээр барьж ашиглалтанд оруулсан А0102 замын Чойр—Сайншанд чиглэлийн ТХЦ-ийн барилга, байгууламж, А0201 замын Улаанбаатар-Мандалговь чиглэлийн ТХЦ-ийн барилга, байгууламж, цахилгааны ажил хийгдэж захиалагч “ЗТХТ” хүлээж авсан боловч 2016 оны урсгал зардалд орон тоо, цалингийн санг батлагдаагүй тул улсын чанартай энэхүү замаар зорчиж буй тээврийн хэрэгслээс замын хураамж авч улсын авто замын санд төвлөрүүлэх ажил хийгдээгүй байна.

### **5.3. Урсгал зардлын төсөв, гүйцэтгэл:**

Монгол Улсын Сангийн сайдын 2015.01.28-ны өдрийн 10 дугаар тушаалаар төсвийн зарлагын санхүүжилтын хуваарийг баталснаар, батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлж гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлыг төрөл зүйл тус бүрээр төлөвлөн хуваарилж, гүйцэтгэлийн мэдээг сар бүр гарган хяналт тавин ажилласан байна. Улсын төсвөөс ТХЦ-үүдийн 2014 он, 2015 онуудын урсгал үйл ажиллагааны зардалд 962.76 сая төгрөг баталснаас батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна.

*/мянган төгрөг/*

№	Үзүүлэлтүүд	2014 он			2015 он		
		Төсөв	Гүйцэтгэл	зөрүү	Төсөв	Гүйцэтгэл	зөрүү
2	Үндсэн ажил үйлчилгээнээс	2,350,000.0	2,901,475.6	551,475.6	2,900,000.0	3,057,821.6	157,821.6
3	Өмнөх оны төсвийн хэмнэлт	1,593,002.5	1,593,002.5			1,938,713.7	
	<b>Нийт орлого</b>	<b>3,943,002.5</b>	<b>4,494,478.1</b>	<b>551,475.6</b>		<b>4,996,535.3</b>	
1.	Үндсэн ба нэмэгдэл цалин	761,868.3	744,228.8	17,639.5	745,835.3	813,149.2	(67,313.9)
2.	НДШимтгэл	83,805.5	81,489.2	2,316.3	82,139.9	37,361.3	44,778.6
3.	Гэрэл, цахилгаан	16,500.0	20,270.8	(3,770.8)	20,200.0	24,502.3	(4,302.4)
4	Халаалт, дулаан	9,808.1	6,875.0	2,933.1	12,700.0	4,704.0	7,996.0
5	Бичиг хэргийн зардал	3,000.0	2,081.6	918.4	2,200.0	433.4	1,766.6
6.	Тээвэр, шатахуун	49,600.0	51,074.6	(1,474.6)	52,546.5	43,078.6	9,467.9
7.	Шуудан холбоо, интернет	3,720.0	3,196.5	523.5	3,600.0	2,616.5	983.5
8.	Тасалбар хэвлэх	12,500.0	12,342.5	157.5	12,590.0	14,404.9	(1,814.9)
9.	Дотоод албан томилолт	7,000.0	9,216.2	(2,216.2)	9,650.0	7,248.9	2,401.1
10.	Эд хогшил худалдан авах	1,120.0	3,206.4	(2,086.4)	3,600.0	1,447.5	2,152.5
11.	Гэрээт цагдаа, үйлчилгээ	2,000.0	750.0	1,250.0			

12	Урсгал засвар	2,800.0	8,871.6	(6,071.6)	4,500.0	735.5	3,764.5
13	Төлбөр хураамж		407.3	(407.3)		659.1	(659.1)
14	Банкны үйлчилгээ шимтгэл		196.2	(196.2)		437.5	437.5
15.	Нормын хувцас	6,040.0	2,548.4	3,491.6	7,200.0	3,052.0	4,148.0
16.	Нэг удаагийн тэтгэмж	3,000.0	4,685.0	(1,685.0)	6,000.0	3,100.8	2,899.2
17.	Бусад зардал		11,321.8	(11,321.8)		5,830.4	(5,830.4)
	<b>Зардлын дүн</b>	<b>962,761.9</b>	<b>962,761.9</b>	<b>-</b>	<b>962,761.7</b>	<b>962,761.9</b>	
	Төсөвт төвлөрүүлэх орлого	1,593,002.5	3,531,716.2			2,871,695.9	
	Сангийн яам 2014 оны орлогоос	-					
	Давсан орлогоос санхүүжсэн төсөл					1,162,077.5	
	<b>Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл</b>	<b>1,387,238.1</b>		<b>551,475.6</b>			
	<b>Зардлын дүн</b>	<b>3,943,002.5</b>	<b>4,494,478.1</b>	<b>551,475.6</b>		<b>4,996,535.3</b>	

Сангийн яамнаас Замын сан /Төлбөр хураах цэг/-н үйл ажиллагааны урсгал зардлын эдийн засгийн ангилалд Зам, тээврийн сайдын багцын төсөвт “бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ” гэсэн эдийн засгийн ангилалаар тусгагдаж ирсэн ба Төвийн захирлын тушаалаар ТХЦ-үүдэд зардлын зүйл тус бүрээр хуваарилан батлуулж ажилласан байна.

Зардлын хэмнэлт хэтрэлтийг зардлын зүйл тус бүрээр нь авч үзвэл: 2014-2015 онд зардлыг нийт дүнгээр нь батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан боловч 2014 онд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 19,955.8 мянган төгрөгөөр, дулаан халаалт, бичиг хэрэг, гэрээт харуул, хөдөлмөр хамгааллын зардлыг тус тус 157.5 – 3,491.6 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна. Харин батлагдсан төсөвгүй бусад зардал гэсэн зардлын зүйлээр 11,321.8 мянган төгрөг зарцуулсан бол урсгал засварын зардлыг 6,071.6 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 3,770.8 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 2,216.2 мянган төгрөгөөр, жижиг эд хогшил худалдаж авах зардлыг 2,086.4 мянган төгрөгөөр, тээвэр, шатахууны зардлыг 1,474.6 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 1,685.0 мянган төгрөгөөр тус тус батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

2015 онд нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 44,778.6 мянган төгрөгөөр, тээвэр, шатахууны зардлыг 9,467.9 мянган төгрөгөөр, дулаан халаалтын зардлыг 7,996.0 мянган төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын зардлыг 4,148.0 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 3,765.5 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 2,899.2 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 2,401.1 мянган төгрөгөөр, жижиг эд хогшил худалдаж авах зардлыг 2,152.5 мянган төгрөгөөр, бичиг хэрэг, гүйлгээний шимтгэлийн зардлыг 437.5 – 1,766.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Харин батлагдсан төсөвгүй бусад зардал гэсэн зардлын зүйлээр мөн 5,830.4 мянган төгрөг зарцуулсан бол, шуудан холбоо, үндсэн болон нэмэгдэл цалингийн зардлыг 67,313.9 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 4,302.4 мянган төгрөгөөр, тасалбар хэвлүүлэх зардал, төлбөр хураамжийн зардлыг 659.1–1,814.9 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Зардлыг бүтцийн хувьд авч үзвэл: Ажилчидтай холбоотой тогтмол зардал буюу ТХЦ-ийн гэрээт ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 2014 онд нийт зардлын 85.8 хувийг зарцуулсан бол 2015 онд 88.3 хувийг, гэрэл, дулааны тогтмол зардалд 2014 онд 2.8 хувийг зарцуулсан бол 2015 онд 3.0 хувийг, тээвэр шатахууны зардалд 2014 онд 5.3 хувийг зарцуулсан бол 2015 онд 4.5 хувийг, бараа үйлчилгээний бусад зардалд 2014 онд нийт зардлын 6.1 хувийг зарцуулсан бол 2015 онд 4.2 хувийг тус тус зарцуулсан байна.

#### **5.4 Орлого, зардлын хуваарилалт, орон тоо, цалингийн сан:**

Төрийн өмчийн хорооны 2015.04.09-ний өдрийн 220 дугаар тогтоолоор “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын бүтэц зохион байгуулалтыг баталсан ба дээрхи бүтцэд “Төлбөртэй замын алба” гэсэн бүтэц батлан тус албанд 2 ажилтан, 111 гэрээт ажилтны орон тоог батласан байна. Төлбөртэй замын алба нь “ЗТХТ” ТӨҮГ-ын бүтэц орон тоонд багтах боловч урсгал зардал нь тусдаа, төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад орж орлого ба санхүүжилтийн эрхийг Зам, тээврийн яамны Төрийн сангаар дамжуулан хийгддэг байна.

Улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслэлээс төлбөр авах үйл ажиллагааг улсын хэмжээнд 15 цэгт зохион байгуулж төлбөр хураах цэгийн 111 ажилтан хэрэгжүүлж ирсэн байна.

“Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төв”-ийн /хуучин нэрээр/ /цаашид АЗХЭШСТ гэх/ захирлын 2014.01.15-ны өдрийн 03 дугаар тушаал, 2015.01.23-ны өдрийн 12 дугаар тушаалаар ТХЦ-үүдийн 2014 он, 2015 онуудад авто замын санд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, үйл ажиллагааны зардлын төсөв, орон тоо, цалингийн сангийн хуваарийг баталсан байна. Гарсан тушаалуудыг хүснэгтээр хураангуйлан харуулбал: /мян.төг/

№	Төлбөр хураах цэгийн нэр	АЗХЭШСТ-ийн захирлын 2014 оны 03-р тушаалаар хуваарилсан орлого, зардал					“ЗТХТ” ТӨҮГ-ын захирлын 2015 оны 11-р тушаалаар хуваарилсан орлого, зардал				
		Хуваарилсан орлого	Хуваарилсан зардлын төсөв	Орлогын дүнд эзлэх%	Орон тоо	Багтагдсан цалин	Хуваарилсан орлого	Хуваарилсан зардлын төсөв	Орлогын дүнд эзлэх%	Орон тоо	Багтагдсан цалин
1	Рашаант ТХЦ	337,000.0	90,319.4	26.8	9	72,882.3	410,000.0	102,450.0	25.0	9	92,250.0
2	Налайх-Тэрэлж	200,000.0	77,356.0	38.7	9	63,600.0	290,000.0	82,660.0	28.5	9	74,910.0
3	Замын-Үүд	350,000.0	62,775.5	17.9	5	52,086.0	490,000.0	86,365.2	17.6	5	65,910.0
4	Хоолтын	242,000.0	81,554.8	33.7	9	64,680.0	330,000.0	96,800.0	19.7	9	84,750.0
5	Өлзийт хороолол	80,000.0	58,442.5	73.1	8	45,750.0	120,000.0	72,000.0	60.0	8	62,250.0
6	Онгийн гүүр	100,000.0	45,652.2	45.7	5	34,020.0	110,000.0	49,620.0	45.1	5	40,620.0
7	Хархорин-Хужирт	100,000.0	47,552.2	47.6	5	34,020.0	70,000.0	42,420.0	60.6	5	32,670.0
8	Дархан	240,000.0	79,063.6	32.9	9	62,760.0	260,000.0	75,000.0	28.8	9	66,000.0
9	Дулаанхааны	130,000.0	56,200.0	43.2	7	43,620.0	140,000.0	56,350.0	40.2	7	48,510.0
10	Гурт	28,000.0	33,460.8	119.5	5	26,280.0	30,000.0	27,570.0	91.9	5	22,320.0
11	Ганц модны	105,000.0	50,712.5	48.3	7	39,750.0	100,000.0	46,020.0	46.0	7	40,320.0
12	Улаангом	35,000.0	34,660.8	99.0	5	26,280.0	40,000.0	30,940.0	77.4	5	24,990.0
13	Түйн гүүр	45,000.0	39,024.5	86.7	5	28,950.0	50,000.0	33,850.0	67.7	5	28,350.0
14	Багануур-Хэрлэн	110,000.0	52,461.9	47.7	7	40,290.0	90,000.0	57,850.0	64.3	7	46,350.0
15	Хангалын гүүр	200,000.0	82,654.2	41.3	9	65,220.0	200,000.0	72,330.0	36.2	9	62,430.0
16	Цанын бааз	48,000.0	70,862.9	147.6	9	61,680.0	170,000.0	30,536.5	18.0	6	35,345.2
	<b>ДҮН</b>	<b>2,350,000.0</b>	<b>962,761.9</b>	<b>41.0</b>	<b>114</b>	<b>761,868.3</b>	<b>2,900,000.0</b>	<b>962,761.9</b>	<b>33.2</b>	<b>114</b>	<b>827,975.2</b>

2014 онд орлогын 41.0 хувийг, 2015 онд орлогын 33.2 хувийг үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Дээрхи тушаалуудаас харахад ТХЦ-үүдэд зардлын төсвийг харилцан адилгүй хуваарилсан байна. Үүнд: Замын-Үүдийн ТХЦ-т 5 орон тоо баталж 2014 онд 350,0 сая төгрөг төвлөрүүлж 62.8 сая төгрөг зарцуулах, 2015 онд 490.0 сая төгрөг төвлөрүүлж 86.4 сая төгрөг зарцуулах төсөв батлагдсан байхад, Өлзийт хорооллын ТХЦ-т 8 хүн ажиллаж 2014 онд 80,0 сая төгрөг төвлөрүүлэн 58,4 сая төгрөг зардал гаргах, 2015 онд 120.0 сая төгрөг төвлөрүүлж 72.0 сая төгрөг зарцуулах, Гуртын ТХЦ 2014 онд 28,0 сая төгрөг төвлөрүүлж 33.5 сая төгрөгийн

зардал гаргахаар алдагдалтай төсөв баталсан бол, 2015 онд 30.0 сая төгрөг төвлөрүүлж 27.6 сая төгрөгийн зардал баталсан гэх мэтээр орлого үр дүнтэй нь уялдуулалгүйгээр урсгал зардлыг баталсан байна.

Өөрөөр хэлбэл Замын-Үүдийн ТХЦ замын санд төвлөрүүлсэн орлогын 17.9 хувийг урсгал зардалдаа зарцуулах бол Өлзийт хорооллын ТХЦ орлогын 73.1 хувийг, Түйн гүүрийн ТХЦ 86.7 хувийг, Улаангом орлогынхоо 99 хувийг, Гуртын ТХЦ оруулсан орлогоо 100 зарцуулаад дахиад нэмж 5.5 сая төгрөг, *Цанын баазын ТХЦ орлогоо 100 зарцуулаад* дахин нэмж 22.9 сая төгрөг нэмж зарцуулахаар төсвийн хуваарь хийсэн байна.

Мөн ТХЦ-үүдэд ажиллах ажилдчын орон тоо цалинг мөн орлого үр дүнтэй нь уялдуулаагүй байна. Жнь: ТХЦ-ийн 1 ажилтан Зам-Үүдийнх 70,0 сая төгрөгийн орлогын оруулж 12.6 саяыг, Рашаантынх 37.4 сая төгрөг оруулж 10.0 саяыг нь, Налайх-Тэрэлжийнх 22.2 сая төгрөг оруулж, 8,6 саяыг нь, Өлзийт хорооллынх 10,0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 7.3 саяыг, Гурт 5.6 сая төгрөг төвлөрүүлэх боловч 6.7 сая төгрөгийг, Улаангом 7.0 сая төгрөг оруулж, 6.93 сая төгрөг тус тус зарцуулах зардлын хуваарийг баталсан байна.

2015 онд автозам ашигласны төлбөр хураамжаас автозамын санд 2,9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж орлогын 33,2 хувь буюу 962.76 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулах зардлын төсөв батлагдсныг “АЗХЭШСТ”-ийн захирлын тушаалаар ТХЦ-д хуваарилсан байна. Энд мөн харилцан адилгүй хуваарилалт хийсэн байна.

Гэхдээ 2014 оны зардлын хуваарилалт шиг алдагдалтай ажиллах хуваарь хийгээгүй боловч Өлзийт хороолол нийт орлогынхоо 60 хувийг, Хархорин 60.6 хувийг, Түйн гүүр 67.7 хувийг, Улаангом 77.4 хувийг, Гурт 91.9 хувийг зарцуулах бол Замын-Үүд 17.6 хувийг, Хоолт 19.7 хувийг тус тус зардал үйл ажиллагаандаа зарцуулах хуваарийг баталсан байна.

### Орон тоо, цалингийн сангийн төсөв, гүйцэтгэл

		2014 оны цалин				2015 оны цалин			
		Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
		О/тоо	Цалин	О/тоо	Цалин	О/тоо	Цалин	О/тоо	Цалин
1	Рашаант ТХЦ	9	72,882.3	9	83,949.4	9	92,250.0	9	82,644.60
2	Налайх-Тэрэлж	9	63,600.0	9	68,169.3	9	74,910.0	9	60,841.14
3	Замын-Үүд	5	52,086.0	5	89,044.3	5	65,910.0	11	120,030.79
4	Хоолтын	9	64,680.0	9	76,554.8	9	84,750.0	9	89,109.25
5	Өлзийт хороолол	8	45,750.0	9	55,575.9	8	62,250.0	9	63,401.90
6	Онгийн гүүр	5	34,020.0	5	36,452.8	5	40,620.0	5	32,708.02
7	Хархорин-Хужирт	5	34,020.0	5	29,415.0	5	32,670.0	5	33,190.56
8	Дархан	9	62,760.0	9	59,387.0	9	66,000.0	9	62,056.83
9	Дулаанхааны	7	43,620.0	7	43,684.4	7	48,510.0	7	43,882.00
10	Гурт	5	26,280.0	4	17,662.0	5	22,320.0	5	23,468.72
11	Ганц модны	7	39,750.0	7	36,111.2	7	40,320.0	7	37,472.60
12	Улаангом	5	26,280.0	5	22,598.1	5	24,990.0	5	23,195.50
13	Түйн гүүр	5	28,950.0	5	25,449.7	5	28,350.0	5	23,944.30
14	Багануур-Хэрлэн	7	40,290.0	7	41,296.6	7	46,350.0	7	57,603.80
15	Хангалын гүүр	9	65,220.0	9	56,140.9	9	62,430.0	9	57,883.90
16	Цанын бааз	9	61,680.0			6	35,345.2		
17	Захиргаа				2,737.4				2,381.4
	<b>ДҮН</b>	<b>113</b>	<b>761,868.3</b>	<b>104</b>	<b>744,228.8</b>	<b>114</b>	<b>827,975.2</b>	<b>111</b>	<b>813,815.21</b>

2014 онд 113 орон тоонд 761.9 сая төгрөгийн цалингийн санг баталснаас гүйцэтгэлээр 104 төлбөр хураагч ажиллан 744.2 сая төгрөг зарцуулж батлагдсан цалингийн санг 17.7 сая



төгрөгөөр хэмнэн ажилласан бол 2015 онд 114 орон тоонд 827.97 сая төгрөгийн цалингийн төсөв баталж гүйцэтгэлээр 111 төлбөр хураагч ажиллан 813.8 сая төгрөг зарцуулж 14.2 сая төгрөг хэмнэсэн үзүүлэлт харагдаж байх боловч төвийн захирлын төсвийн зүйлээр баталсан /цалингийн сан-745.8 сая төгрөг/ тушаалтай зөрүүтэй байдлаар гарсан байна.

2014 онд цалингийн зардлыг нийт дүнгээр нь 17.6 сая төгрөгөөр хэмнэсэн боловч Рашаантын ТХЦ 11.1 сая төгрөгөөр, Налайх-Тэрэлжийн гүүрийн ТХЦ 4.6 сая төгрөгөөр, Замын-Үүдийн ТХЦ 36.9 сая төгрөгөөр, Хоолтын ТХЦ 11.9 сая төгрөгөөр, Өлзийтийн ТХЦ 9.8 сая төгрөгөөр тус тус цалингийн санг нь хэтрүүлсэн байна.

2015 онд өмнөх оноос орон тоо 7 хүнээр, цалингийн сан 69.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. 2015 онд цалингийн санг 14.2 сая төгрөгөөр хэмнэсэн боловч Замын-үүдийн ТХЦ-ийн орон тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор, цалингийн санг нэмэгдүүлээгүй тул тус цэг батлагдсан цалингийн санг 54.1 сая төгрөгөөр хэтрүүлсэн үзүүлэлттэй байна.

Замын-Үүдийн ТХЦ болон тээврийн хэрэгслийн тэнхлэгийн даацыг хэмжих авто пүүг суурьлуулах барилгын ажлыг “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-н хүрээнд 425,6 сая төгрөгөөр Чойр-Сайншанд-Замын-үүд чиглэлийн хатуу хучилттай авто замын 114 дэх км-т хийж гүйцэтгэн Зам, тээврийн сайдын 2014 оны 190 дугаар тушаалаар 2014.08.12-ний өдрөөс үйл ажиллагаагааг нь эхлүүлсэн боловч Замын-Үүдийн ТХЦ-ийн орон тоог нэмэгдүүлсэн тушаал шийдвэр гараагүй байна.

ТХЦ-ийн ажилтнуудын цалин нь үндсэн цалин, орлогыг нэмэгдэл, гарааны нэмэгдэл, хоол унааны нэмэгдэлээс бүрдсэн байна. Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2006.07.27-ны өдрийн 127 дугаар тушаалаар батлагдсан "Олон улс болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж буй авто тээврийн хэрэгслээс төлбөр хураах үйл ажиллагааны журам"-ын 3.7-д “Төлбөр хураагчид ажилласан хоногт нь үндсэн цалин олгохоос гадна орлогын дүнгээс 10%-иар бодож нэмэгдэл цалин олгоно” гэж заасны дагуу үндсэн цалин нэмэгдлийг тооцож Зам, тээврийн яамаар батлуулж, мөрдөн ажиллаж ирсэн байна.

### **Зургаа. Хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэл**

2013 оны санхүүгийн үр дүнгээр 1,513.6 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан боловч хөрөнгө оруулалтанд зардал гаргаагүй, харин 2015 онд ТХЦ-үүдэд хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг санхүүжүүлэхтэй холбоотойгоор Зам, тээврийн сайдын 2 тушаал гарсан байна. Үүнд:

1. Зам, тээврийн сайдын 2015.06.24-ний өдрийн **180** дугаар тушаал: Энэхүү тушаалаар Төлбөр хураах цэг /Авто замын сан /-гийн 2013 оны давсан орлогоос санхүүжүүлэн хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 11 төсөл арга хэмжээг 1,122.7 сая төгрөгт, тоног төхөөрөмжийн 3 арга хэмжээг 210.7 сая төгрөгт, бусад 4 арга хэмжээг 259.6 сая төгрөгт нийт 18 төсөл арга хэмжээний жагсаалт батлан санхүүжилтэнд **1,593.0** сая төгрөг зарцуулах төсөв баталсан байна.

2. Зам, тээврийн сайдын 2015.12.18-ны өдрийн **356** дугаар тушаалаар Авто замын сан /Төлбөр хураах цэг/-гийн 2014 оны давсан орлогоос санхүүжүүлэн хэрэгжүүлэх 3 төсөл арга хэмжээнд 330,0 сая төгрөгийн санхүүжилт хийх төсөв баталсан байна.

Дээрхи тушаалуудаар батлагдсан төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай

хуулийн дагуу шуурхай зохион байгуулахыг “ЗТХТ” ТӨҮГ-д, шаардлагатай санхүүжилтийг тухай бүрт нь санхүүжүүлж байхыг яамны Санхүү, эдийн засгийн хэлтэст, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт тус тус даалгасан байна.

Дээрхи тушаалын хэрэгжилтийг хангах үүднээс “ЗТХТ” ТӨҮГ-ын захирлын 2015.06.26-ны өдрийн 78 дугаар тушаалаар “ЗТХТ” ТӨҮГ-ын хяналтын инженер М.Ган-Эрдэнээр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй “Үнэлгээний хороо”-г байгуулж үнэлгээний хорооноос дээрх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичгийг бүрдүүлж сонгон шалгаруулалт явуулсан байна. Үүнд:

1. Сайдын 2015 оны 180 дугаар тушаалаар батлагдсан төсөл хөтөлбөрөөс **948,2 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй **5 төсөл** арга хэмжээнд **нээлттэй тендер** зарлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулсан бол, **351.1 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй **5 төсөл** арга хэмжээг **харьцуулалтын аргаар** гүйцэтгэгчийг сонгон гэрээ байгуулсан байна. Харин 2013-2014 онд хийгдсэн боловч санхүүжилт нь шийдэгдээгүй байсан **29,4 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй **3 төсөл** арга хэмжээний санхүүжилтийг /“Өвөрхангай-А33А” ТӨХК, “Хархорин-А33А” ТӨХК, “Их богд зам” ХХК/ гүйцэтгэгчид санхүүжилтийг **шууд олгосон** байна.

Сайдын 2015 оны 180 дугаар тушаалын жагсаалтанд орж төсөв нь батлагдсан нийт **264.3 сая** төгрөгийн төсөвтэй **5 төсөл** хөтөлбөр хэрэгжээгүй байна. Үүнд: 238.95 сая төгрөгийн төсөвтэй “Авто замын тухай хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих, мэдээ, мэдээллээр хангах, сурталчлах” арга хэмжээ, 7,5 сая төгрөгөөр баталсан “ТХЦ-т төлөвлөгөөт хяналт шалгалт хийх”, 6.6 сая төгрөгийн төсөвтэй “ТХЦ-ийн аудитын төлбөр”, 6,56 сая төгрөгийн төсөвтэй “Багануур, Хэрлэнгийн гүүр, Замын-Үүд, Өлзийт хороолол, Хоолтын ТХЦ-үүдийн авто жинг баталгаажуулах”, 4.7 сая төгрөгийн төсөвтэй ТХЦ-үүдэд тавилга нийлүүлэх гэсэн төслүүд хэрэгжээгүй байна.

2. Сайдын 2015.12.18-ны өдрийн 356 дугаар тушаалаар Авто замын сангийн 2014 оны давсан орлогоос санхүүжүүлэх 330,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ажил батласнаас 2 ажил нь хийгдэж комисс ажиллаж ажлыг нь хүлээн авсан боловч санхүүжилтийг олгоогүй, 1 ажил нь хийгдээгүй санхүүжилтийн эрхийг орон нутагт нь шилжүүлэхээр сайдын тушаал гарсан байна.

### **Зам, тээврийн сайдын 2015 оны 180-р тушаалаар батлагдсан Төлбөр хураах цэг /Авто замын сан/-ийн 2015 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ**

Санхүүжилтийн эх үүсвэр: Авто замын сан /ТХЦ/-ийн 2013 оны давсан орлого

№	Бараа ажил үйлчилгээний нэр төрөл , тоо хэмжээ хүчин чадал	Хэрэгжүүлэх хугацаа	Батлагдсан төсөвт өртөг /мян.төг/	2015 онд санхүүжсэн дүн /мян.төг/	Хуулиар авах ажиллагаанд мөрдсөн хувирам	Гэрээ байгуулсан огноо дугаар, ажил дуусгаж ххлээлгэн өгөх	Гүйцэтгэгч байгууллага
А	<b>Хөрөнгө оруулалт:</b>		<b>1,122,734.7</b>	<b>967,227.5</b>			
1	А14 замын Ховдын Булган чиглэлд ТХЦ-ийн барилга болон авто пүүний байр, замын байгууламж барих /Ховдын Булган/	2015	310,925.9	304,535.9	НТШ	2015.08.19 №92 2015.11.15	“Жиансу Жунжиан Жианши” ХХК
2.	А0102 замын Чойр—Сайншанд чиглэлд ТХЦ-ийн барилга, байгууламж барих	2015	157,257.8	152,122.1	НТШ	2015.08.19 №93	“Хүжийн гал” ХХК
3.	А0201 замын Улаанбаатар — Мандалговь чиглэлд ТХЦ-ийн барилга, замын байгууламж	2015	157,257.8	152,116.0	НТШ	2015.08.19 №94	“Хүжийн гал” ХХК
4.	ТХЦ-ийн тоноглол, тохижилтийн ажил	2015	157,257.8	105,322.1		2015.08.19	“Хөвчийн гал”

	/Онгийн гүүр, Хархорин-Хужирт, Өндөрхаан/				НТШ	№95	ХХК
5.	А0201 зам Улаанбаатар-Мандалговь чиглэлийн улсын чанартай автозамын авто тээврийн хэрэгслэлийн жин хэмжигч пүүгийн орж гарах уулзварыг хатуу хучилттай болгох /Өлзийт/	2015	79,324.6	0.0			
6.	А0501 замын Улаанбаатар—Өндөрхаан чиглэлийн улсын чанартай авто замын авто тээврийн хэрэгслэлийн жин хэмжигч пүү рүү орж гарах, уулзварыг хатуу хучилттай болгох барилгын ажил /Багануур-Хэрлэн/	2015	76,258.1	74,430.3	ХА	2015.07.28 №63	“Наранбулагхан” ХХК
7.	А0101 замын Улаанбаатар—Чойр чиглэлийн улсын чанартай авто замын авто тээврийн хэрэгслэлийн жин хэмжигч пүү рүү орж гарах, уулзварыг хатуу хучилттай болгох барилгын ажил /Налайх-Хоолт/	2015	79,471.2	77,782.5	ХА	2015.07.28 №60	“SEZAM” ХХК
8.	Хүнд даацын тээврийн хэрэгслэлийг хязгаарлах зурвас, шуудуу татах ажил /Замын-Үүдийн ТХЦ/	2015	75,572.0	75,235.7	ХА	2015.07.28 №64	“Борхойн зам” ХХК
9.	Онгийн гүүрийн ТХЦ-ийн гадна зам, талбайн тохижилт, хурд сааруулагч, ариун цэврийн өрөө /Өвөрхангай/	2015	9,973.8	9,973.9	ШХА	ТХЦ-2013 19/67	“Өвөрхангай АЗЗА” ТӨХК
10	Элсэнтасархай-хархорин чиглэлийн авто замын Хархорин-Хужиртын ТХЦ-ийн гадна зам, талбайн тохижилт, хурд сааруулагч, ариун цэврийн өрөө /Өвөрхангай аймаг/	2015	9,959.1	6,232.4	ШХА	ТХЦ-2013 18/66	“Хархорин АЗЗА” ТӨХК
11	Түйн гүүрийн ТХЦ-ийн гадна зам, талбайн тохижилт, хурд сааруулагч, ариун цэврийн өрөө /Баянхонгор/	2015	9,476.6	9,476.6	ШХА	ТХЦ-2013 19/67	“Их Богд зам” ХХК
<b>В</b>	<b>Тоног төхөөрөмж:</b>		<b>210,657.5</b>	<b>194,850.0</b>			
1	ТХЦ-үүдийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах гэмдэг, гэмдэглэгээ, тоног төхөөрөмж /Замын-үүд, Хэрлэнгийн гүүр, Хоолт, Өлзийт/	2015	165,477.5	155,000.0	НТШ	№АЗС/155 2015.09.25	“ӨҮ ЭЛ” ХХК
2	ТХЦ-үүдийн байцаагч, операторчдын тавилга, эд хогшил /Замын-үүд, Хэрлэнгийн гүүр, Хоолт, Өлзийт/	2015	4,680.0				
3	Зөөврийн авто пүү худалдан авах	2015	39,850.0	39,850.0	ХА	2015.07.28 №66	“Ганхэмжүүр” ХХК
<b>С</b>	<b>Бусад:</b>		<b>259,610.3</b>	<b>0.0</b>			
<b>1</b>	Авто замын тухай хууль, тогтоомж-ийн биелэлтэнд хяналт тавих, мэдээ мэдээллээр хангах, сурталчлах арга хэмжээний зардал	2015	238,950.3	0.0			
<b>2</b>	ТХЦ-г төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	2015	7,500.0	0.0			
<b>3</b>	Төлбөр хураах цэгийн аудитын төлбөр	2015	6,600.0	0.0			
<b>4</b>	Багануур-Хэрлэнгийн гүүр, Замын-Үүд, Өлзийт хороолол, Хоолтын ТХЦ-үүдийн авто жинг баталгаажуулах	2015	6,560.0	0.0			
	<b>НИЙТ ДҮН</b>		<b>1,593,002.5</b>	<b>1,162,077.5</b>			

ЗТС-ын 2015 оны 180 дугаар тушаалаар батлагдсан 2013 оны давсан орлогоос санхүүжүүлэн хэрэгжүүлэх 1,593.0 сая төгрөгийн санхүүжилттэй 18 төсөл хөтөлбөрөөс 2015 онд 12 төсөл хэрэгжиж 1,162,077.5 мянган төгрөгийн санхүүжилтийг хийснээс 12 гүйцэтгэгчид 1,086,117.8 мянган төгрөг, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн ЗТХТ-д 21,370.3 мянган төгрөг, норм нормативын санд 1,531.4 мянган төгрөг, барьцаа баталгаанд 53,057.9 мянган төгрөг тус тус шилжүүлсэн байна.

Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн хүрээнд дээрхи хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг ажлын хэсэг явж газар дээр нь шалган дүнг удирдлагуудад танилцуулан ажилласан.

## **6.1. Нээлттэй тендер шалгаруулалтаар:**

**6.1.1.** А14 замын “Ховдын Булган чиглэлийн ТХЦ-ийн барилга болон авто пүүний байр, замын байгууламж”-ийн 310,925.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар “Жиансу Жунжиан Жианши” ХХК 308,450.0 мянган төгрөгийн өртгөөр хийхээр шалгарч захиалагч ЗТХТ-тэй 2015.08.19-ны өдөр 95 тоот гэрээ байгуулан 2015.08.19-нд ажлаа эхлүүлж 2015.11.15-нд дуусган хүлээлгэж өгөхөөр заасан байна.

Гэтэл “Жиансу Жунжиан Жианши” ХХК нь Төлбөр хураах цэг, авто пүүний байр барих талбай гаргаж 150 тонны даац бүхий пүү байрлуулсан боловч холбогдох байр, барилга байгууламж баригдаагүй байх үед захиалагч “ЗТХТ” ТӨҮГ-ын захирлын 2015.11.26-ны өдрийн 230 дугаар тушаалаар ажил хүлээн авах комисс томилогдон Ховдын Булган чиглэлийн замд ТХЦ-ийн барилгын ажил дууссан гэж дугаар он, сар өдөргүй акт үйлдэн санхүүжилтийг 100 хувь олгох шийдвэр гаргасан байна. Иймд Яамны төрийн сангаар дамжуулан гүйцэтгэгч “Жиансу Жунжиан Жианши” ХХК-д 2015.11.27-нд 92,618.65 мянган төгрөг, 2015.12.09-нд 188,928.94 мянган төгрөг гүйцэтгэгчид нийт 281,547.59 төгрөг, ЗТХТ-д захиалагчийн хяналт хэрэгжүүлсний зардалд 7,279.4 мянган төгрөг, норм нормативын санд 482.1 мянган төгрөг, барьцаа баталгаанд 15,226.8 мянган төгрөг нийт 304,535.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

**6.1.2.** А0102, А0201 замын 314.52 (157,26+157,26) сая төгрөгийн төсөвт өртөгтэй Чойр—Сайншанд чиглэлд болон Улаанбаатар—Мандалговь чиглэлд ТХЦ-ийн барилга байгууламж барих гэсэн 2 ажилд /тус тусдаа тендер зарлагдсан/ нээлттэй тендер шалгаруулалтаар “**Хүжийн гал констракшн**” ХХК 309,66 сая төгрөгт хийхээр шалгарч 2015.08.19-нөөс ажлаа эхлүүлж 2015.11.15-нд дуусган хүлээлгэж өгөхөөр ЗТХТ-тэй 2015.08.19-ны өдөр 93, 94 тоот гэрээнүүдийг байгуулсан байна. ЗТХТ-ын захирлын 2015.12.04-ны өдрийн 236 дугаар тушаалаар “Ажил хүлээж авах комисс” томилогдсон ба комиссоос “Ажил зураг төсвийн дагуу бүрэн хийгдсэн тул санхүүжилтийг 100 хувь олгох” гэсэн шийдвэрийг 2015.12.07 болон, 2015.12.08-нд тус тус гаргасан байна.

ЗТЯ-аас “Хүжийн гал констракшн” ХХК 2015.11.19-нд 166,36 сая төгрөг, 2015.12.04-нд 95,79 сая төгрөг, 2015.12.24-нд 21,05 сая төгрөг нийт 283,21 сая төгрөгийг шилжүүлсэн ба, ЗТХТ-д захиалагчийн хяналтын зардалд 7,23 сая төгрөг, норм, нормативын санд 0,41 сая, барьцаа баталгаанд 12,87 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна. Өөрөөр хэлбэл нийт санхүүжилтийн 92,6 хувийг зарцуулсан байна.

**6.1.3.** “ТХЦ-ийн тоноглол, тохижилт” /Хархорин—Хужирт, Онгийн гүүр, Өндөрхаан/-ын 157,26 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулж “Хөвчийн зам” ХХК 156,88 сая төгрөгт хийхээр шалгарч 2015.08.19-ний өдөр ажлаа эхлүүлж 2015.11.15-нд дуусган хүлээлгэж өгөхөөр ЗТХТ-тэй 2015.08.19-ны өдөр 95 тоот гэрээг байгуулсан байна. ЗТХТ-ын захирлын 2015.11.26-ны өдрийн 230 дугаар тушаалаар “Ажил хүлээж авах комисс” томилогдсон ба комиссын акт 2015.12.03-нд гарсан байна. Гэтэл 2015.11.27-нд гүйцэтгэгчид 95,3 сая төгрөг, ЗТХТ-д 4,57 сая төгрөг, норм, нормативын санд 0,16 сая төгрөг, барьцааны дансанд 5,27 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна. Өөрөөр хэлбэл комисс ажиллаагүй, ажлыг хүлээж аваагүй байхад санхүүжилтын 67,1% буюу 105,32 сая төгрөг олгогдсон байна.

Ажлын хэсгээс гүйцэтгэлийг газар дээр нь шалгахад ажил дутуу, байрны гадна талыг сэндвичээр бүрэх ажлыг плитагаар хийж гүйцэтгэсэн нь гэрээний ерөнхий нөхцөлийн 37.1 дэх шаардлагыг зөрчсөн ба ажлыг бүрдэл дутуу гүйцэтгэсэн, тендерийн баримт бичгийн 4 дүгээр бүлэг техникийн тодорхойлолтод заасан гэрэл гэрэлтүүлэг болон, барилгын материалыг зөрүүтэй тодорхойлсон байна. Мөн Өндөрхааны чиглэлд тохижилтын ажил хийгдээгүй бөгөөд 51,56 сая төгрөг олгогдоогүй байна.

**6.1.4. “ТХЦ-ийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдэг, тэмдэглэгээ, тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажил гүйцэтгэх” гэсэн 165,47 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд нээлттэй тендер зарлаж “ӨҮ ЭЛ” ХХК 155,0 сая төгрөгт нийлүүлэхээр шалгарч 2015.09.25-нд АЗС/155 тоот гэрээг “ЗТХТ” ТӨҮГ-тай байгуулсан байна. “ЗТХТ” ТӨҮГ-ын захирлын 2015.11.26-ны өдрийн 228 дугаар тушаалаар “Ажил хүлээж авах комисс”-ыг томилсон байна. Комиссын шийдвэрт шаардлага хангасан байх тул санхүүжилтийг 100% олгох гээд баталгаат засварын хугацаанд тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах, гэрэл гэрэлтүүлгийн дутуу ажлыг гүйцээх, техник хэрэгсэлд гарсан гэмтлийг хариуцах гэсэн байна.**

Ажлын хэсгээс дээрх комиссын акт нь дутуу ажлуудыг баталгаат хугацаанд хийлгэх тухай тусгасан нь ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу барилгын ажлыг бүрэн дууссаны дараа ашиглалтад оруулах тухай 4.12.3.5-д заасан “... ажлыг дутуу, чанаргүй хийсэн хууль, тогтоомж, норм, дүрмийн заалт, стандартын шаардлага зөрчсөн бол комисс ажиллахыг тодорхой хугацаагаар хойшлуулах ...” гэснийг зөрчсөн ба “Налайх, Өлзийт, Хархорин-Хужирт, Онгийн гүүр чиглэлийн ТХЦ-ийн гэрэлтүүлгийн ажил бүрэн хийгдээгүй байсан.

Иймд Замын-Үүд, Хоолт, Өлзийт хорооллын ТХЦ-үүдэд хийгдсэн дээрхи ажлуудын чанар байдлыг шалган ахлагч нараас судалгаа авахад автомат хаалтууд шинээр тавьсаны дараа хэвийн ажиллаж байсан ч өвлийн хүйтний улиралд гацаж эвдрэх асуудлууд их үүссэн, Замын тэмдэглэгээнүүд хөдөлгөөнтэй, сайн суурилуулаагүй, камерын холын харагдах байдал муу, хүчтэй салхитай үед унтарч асдаг, механик гэмдлүүд их гардаг гэсэн гомдол гаргаж байсан.

## **6.2. Харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан:**

**6.2.1.** Багануур Хэрлэнгийн чиглэлийн 76.26 төгрөгийн төсөвт өртөгтэй “А0501 замын Улаанбаатар—Өндөрхаан чиглэлийн улсын чанартай авто зам, автотээврийн хэрэгслийн жин хэмжигч пүүгийн орж гарах уулзварыг хатуу хучилттай болгох замын ажил”-г 75,76 сая төгрөгт хийхээр “Наранбулагхан” ХХК шалгарснаар 2015.07.28-нд ажлыг эхлүүлж 2015.09.15-нд дуусган хүлээлгэж өгөхөөр “ЗТХТ” ТӨҮГ-тай 2015.07.28-ны өдөр 63 тоот гэрээг байгуулсан байна.

“ЗТХТ” ТӨҮГ-ын захирлын 2015.11.26-ны өдрийн 229 дүгээр тушаалаар “Ажил хүлээж авах комисс” томилогдсон ба комиссын 2015.11.27-ны өдрийн 5/2015 дугаар актаар “Ажил бүрэн хийгдсэн тул санхүүжилтийг 100 хувь олгох” гэсэн шийдвэрийг гаргасан байна. Яамнаас 2015.12.11-нд гүйцэтгэгчид 69,2 сая төгрөг, ЗТХТ-д 1,3 сая төгрөг, норм, нормативын санд 0,12 сая төгрөг, барьцааны дансанд 3,7 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

**6.2.2.** Налайх-Хоолтын чиглэлийн 79,47 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “А0201 замын Улаанбаатар—Чойр чиглэлийн улсын чанартай авто замын авто тээврийн хэрэгслийн жин хэмжигч пүүгийн орж гарах уулзварыг хатуу хучилттай болгох замын барилгын ажил”-ыг

79,17 сая төгрөгт хийхээр “SEZAM” ХХК шалгарч 2015.07.28-нд эхлүүлж 2015.08.21-нд хийж дуусган хүлээлгэж өгөхөөр “ЗТХТ” ТӨҮГ-тай 2015.07.28-ны өдөр 60 тоот гэрээ байгуулан ажлаа эхлүүлсэн байна.

“ЗТХТ” ТӨҮГ-ын захирлын 2015.08.24-ны өдрийн 132 дугаар тушаалаар “Ажил хүлээж авах комисс” томилогдсон ба комиссын 2015.08.24-ны өдрийн 01/2015 дугаар актаар “Ажил бүрэн хийгдсэн тул энэ өдрөөс байнгын ашиглалтад оруулах” гэсэн шийдвэрийг гаргасан байна. Яамнаас 2015.11.27-нд гүйцэтгэгчид 72,41 сая төгрөг, ЗТХТ-д 1,3 сая төгрөг, норм, нормативын санд 0,12 сая төгрөг, барьцааны дансанд 3,8 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

**6.2.3.** Замын-Үүдийн ТХЦ-д хийгдэх 79,17 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүнд даацын тээврийн хэрэгслэлийг хязгаарлах зурвас, шуудуу татах ажил”-ыг 75,23 сая төгрөгт хийхээр “Борхойн зам” ХХК шалгарч 2015.07.28-нд эхлүүлж эхлүүлж 2015.08.15-нд дуусган хүлээлгэж өгөхөөр “ЗТХТ” ТӨҮГ-тай 2015.07.28-ны өдөр 64 тоот гэрээ байгуулсан байна.

“ЗТХТ” ТӨҮГ-ын захирлын 2015.08.20-ны өдрийн 130 дугаар тушаалаар “Ажил хүлээж авах комисс” томилогдсон ба комиссын 2015.08.30-ны өдрийн 02/2015 дугаар актаар “Ажил бүрэн хийгдсэн тул санхүүжилтийг 100 хувь олгох” гэсэн шийдвэрийг гаргасан байна. Ажлын хэсгээс тус газар шорооны ажил нь шаардлагын хэмжээнд бүрэн хийгдсэн гэж үзсэн.

Яамнаас 2015.11.19-нд гүйцэтгэгчид 74,0 сая төгрөг, ЗТХТ-д 1,12 сая төгрөг, норм, нормативын санд 0,11 сая төгрөг төгрөгийг тус тус шилжүүлсэн байна. Харин баталгаат хугацааны барьцаа хөрөнгө авч үлдээгүй байна.

**6.2.4.** Тоног төхөөрөмж нийлүүлэх 40,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Зөөврийн авто пүү худалдан авах” ажлыг “Ган хэмжүүр” ХХК нийлүүлэхээр “ЗТХТ” ТӨҮГ-тай 2015.07.28-ны өдөр 66 тоот гэрээ байгуулсан байна. Гэтэл “Зөөврийн авто пүү худалдан авах” ажил хэрэгжээгүй тул яамны барьцааны дансанд 39.5 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

**6.3.** Зам, тээврийн сайдын 2015 оны 356 дугаар тушаалаар ТХЦ-ийн 2014 оны давсан орлогоос санхүүжүүлэн хэрэгжүүлэх 330.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төслийг батласан байна. Дээрхи төсөлд шинээр баригдсан А0201 дугаартай Улаанбаатар-Мандалговь чиглэлд ТХЦ-ийн барилга байгууламжийг цахилгааны шугамаар холбох ажлыг “Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК-ийн “Дундговь ЦТС салбарыг, А0102 дугаартай Улаанбаатар-Сайншанд чиглэлд ТХЦ-ийн барилга байгууламжийг цахилгааны шугамаар холбох ажлыг “Чингүүд” ХХК-иудыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, тус бүртэй гэрээ байгуулсан бөгөөд сонгогдсон компаниуд ажлыг 100% өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

**6.3.1.** “А0102 дугаартай Чойр—Сайншанд чиглэлд шинээр баригдсан ТХЦ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөө суурилуулах, угсрах 50,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд “Чингүүд” ХХК 48,158.91 мянган төгрөгт хийхээр шалгарч “ЗТХТ” ТӨҮГ-тай 2015.12.02-нд АГГ/193 тоот гэрээ байгуулсан байна.

Энэ ажлыг хүлээж авах комисс томилсон төвийн захирлын тушаал гараагүй байна. Гэтэл ЗТХТ-өөс 2015.12.14-ны өдөр комисс ажиллан 12/2015 акт гарган “Төмөр бетон тулгуур бүхий 700 метр 10кВ хүчдлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, 10/0,4 кВ 50кВА АТП дэд өртөөний угсралтын ажлыг ЦБА-ын дүрэм ба ТАД, ЦБАҮМААД, зааврын дагуу чанарын өндөр

түвшинд гүйцэтгэсэн тул ашиглалтанд авч 100% санхүүжилтийг олгохоор санал нэгтэйгээр шийдвэрлэв” гэсэн акт үйлдсэн байна.

Хяналт, шалгалтаар энэ ажил дуусаагүй 90%-ийн гүйцэтгэлтэй байсан ба дэд өртөөнөөс ТХЦ хүртэлх 700 метр кабелийн ажил нь түр байдлаар шороогоор булсан байдалтай байв.

**6.3.2** “А0201 дугаартай Улаанбаатар—Мандалговь чиглэлд шинээр баригдсан ТХЦ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөө суурилуулах, угсрах 50,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахад Дундговь аймгийн “Цахилгаан түгээх сүлжээ” салбар шалгарч захиалагч “ЗТХТ” ТӨҮГ-тай 2015.12.08-нд 2015/11 тоот гэрээ байгуулан ажилласан байна.

Энэ ажлыг хүлээж авах комисс томилсон төвийн захирлын тушаал гараагүй боловч 2015.12.14-ны өдөр комисс ажиллан 11/2015 тоот акт үйлдсэн байна. Комиссын актанд “Төмөр бетон тулгуур бүхий 1000 метр 6кВ хүчдлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, 6/0,4 кВ 50кВА КТПН дэд өртөөний угсралтын ажлыг ЦБА-ын дүрэм ба ТАД ЦБАҮМААД, зааврын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэсэн тул ашиглалтад хүлээн авч 100% санхүүжилтийг олгохоор санал нэгтэйгээр шийдвэрлэв” гэсэн акт үйлдсэн байна.

Хяналт шалгалтаар энэ ажил дуусаагүй 95%-ийн гүйцэтгэлтэй байсан бөгөөд тэжээлийн эх үүсвэрт холбох ажил дутуу байсан ба захирал Мягмарсүрэн хэлэхдээ “ТХЦ ажиллаж эхлэнгүүд бид шууд холболтыг хийнэ. Санхүүжилтын асуудлыг яаралтай шийдвэрлэж өгөхийг ЗТХТ, ЗТЯ-нд удаа дараа тавьсан шийдвэрлэхгүй байгаа” талаар тайлбар хийсэн.

Сүхбаатар аймагт шинээр баригдах 230,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТХЦ /Өндөрхаан– Баруун-Урт чиглэл/-ийн цахилгаан хангамж, замын өргөтгөлийн ажлыг орон нутагт эрхийг шилжүүлэх болсон шалтгаанаар ЗТС-ын 2015 оны 356 дугаар тушаалыг нийтэд нь хүчингүй болгосноор 2015 онд ажил нь хийгдэж комисс ажиллан хүлээн авсан Мандалговийн шинэ ТХЦ-ийн цахилгааны ажил, Сайншандын шинээр баригдсан ТХЦ-ийн цахилгааны ажлын санхүүжилтийг олгох боломжгүй болсон байна.

#### **6.4. Шууд худалдан авалтаар:**

Зам, тээврийн сайдын 2015 оны 180 дугаар тушаалаар батлагдсан.

- Онгийн гүүрийн ТХЦ-ийн 9.97 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гадна зам, талбайн тохижилт, хурд сааруулагч, ариун цэврийн өрөө,
- Элсэнтасархай —Хархорин чиглэлийн автозамын 9,96 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хархорин—Хужиртын ТХЦ-ийн гадна зам, талбайн тохижилт, хурд сааруулагч, ариун цэврийн өрөө
- Түйн гүүрийн ТХЦ-ийн 9.48 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гадна зам, талбайн тохижилт, хурд сааруулагч, ариун цэврийн өрөө зэрэг нийт 29,41 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй ажил 2013-2014 онд хийгдэж санхүүжилт нь олгогдоогүй байсныг “Өвөрхангай-АЗЗА” ТӨХК-д 9,82 сая төгрөг, “Хархорин АЗЗА” ТӨХК-д 6,14 сая төгрөг, “Их богд зам” ХХК-д 9,27 сая төгрөг тус тус олгосноос гүйцэтгэгчид 25,23 сая төгрөг, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн “ЗТХТ” ТӨҮГ-т 0,41 сая төгрөг, норм нормативын санд 0,04 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

## **Долоо. Үндсэн хөрөнгө**

2014 онд 348.4 мянган төгрөгийн тавилгыг төсвийн хөрөнгөөр худалдан авч орлогод авсан ба хасагдсан үндсэн хөрөнгө байхгүй байна.

Харин 2015 онд Зам, тээврийн сайдын 2015 оны 180 дугаар тушаалаар батлагдсан төсөл арга хэмжээний хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлууд болох Сайншандын ТХЦ-ийн барилга, замын байгууламж, Мандаговийн ТХЦ-ийн барилга, замын байгууламж, Онгийн гүүр, Хархорин-Хужиртын ТХЦ-т хийгдсэн байрны саравч тохижилтын ажил, Багануур-Хэрлэнгийн гүүрийн ТХЦ болон Хоолтын ТХЦ-ийн пүү рүү орох гарах гарцыг хатуу хучилттай болгосон зэрэг нийт 561,773.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг барилга байгууламж дансанд, автомат хаалт, хяналтын камер, гэрэл, гэрэлтүүлэг автомат тоологч, мэдээлэл хадгалах систем, тэмдэг, тэмдэглэгээ зэрэг 155.0 сая төгрөгийг тоног төхөөрөмж дансанд тус тус орлогод авч данс бүртгэлд тусгасан байна. Эдгээр үндсэн хөрөнгийг орлого авахдаа Төрийн өмчийн хорооноос зөвшөөрөл аваагүй байна.

Мөн Замын-Үүдийн ТХЦ-д хийгдсэн “Хүнд даацын тээврийн хэрэгслэлийг хязгаарлах зурвас, шуудуу татах” 75.26 сая төгрөгийн төсөвтэй хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг комисс ажиллан хүлээн авч санхүүжилтийг 100 олгосон боловч орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна.

### **Найм. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгалалт хамгаалалтын талаар**

ТХЦ-ийн төлбөр тооцооны үнэт цаас буюу тасалбарыг тухайн цэгийн ахлагч нар Зам, тээврийн хөгжлийн төвийн няраваас актаар хүлээж авдаг. Актыг ТХЦ-ийн санхүү, бүртгэл хариуцсан мэргэжилтэн хянаж, гарын үсэг зурдаг. Үнэт цаас /тасалбар/-ны зарцуулалтын тайланг ТХЦ-ийн ахлагч тасалбарын сери, төрөл тус бүрээр гаргаж, сард 1 удаа ЗТХТ-д тайлагнадаг.

ТХЦ-ийн 2014, 2015 оны үнэт цаасны тайлан, холбогдох баримт бичгийг шалгаж, Өлзийтийн ТХЦ, Замын Үүдийн ТХЦ, Хоолтын ТХЦ-ийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцахад дараах байдалтай байв. Үүнд:

1. Үнэт цаас /тасалбар/-ын үлдэгдлийг борлуулалтын орлоготой харьцуулан тулгалт, тооллого хийхэд үлдэгдэл үнэт цаасны сери, дугаар таарч, зөрчилгүй байв.
2. Зарим ТХЦ үнэт цаас /тасалбар/-ыг хадгалах цоожтой шүүгээ, сейфгүй учир алдах, гээх эрсдэлтэй байна.
3. ТХЦ дээр ашиглаж байгаа үнэт цаас /тасалбар/-ны бүртгэл, тооцоо, хүлээлцэх баримт нь гар ноорог байдлаар хийгдсэн, санхүүгийн баримт гэж үзэх боломжгүй байв.
4. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны бүртгэлийг хийхдээ ач холбогдол бага өгч хийж байна.
5. Ээлжийн ажлын тайланг албаны бус үг хэллэгээр, найруулгын алдаатай хийж байна.
6. Шинээр барьсан ТХЦ-ийг ашиглалтад оруулаагүйгээс улсын төсөвт орох орлогыг алдаж байна.

ТХЦ-ийн үнэт цаас /тасалбар/-ны төлбөр, тооцоо, хадгалалт хамгаалалтын үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийж үзэхэд өндөр эрсдэл байхгүй, дараах ажил дунд эрсдэлтэй гарав. Үүнд:



1. ТХЦ-ийн үйл ажиллагааны орлогыг банкинд тушаахгүй байх,
2. Борлуулалтын орлогыг хувьдаа ашиглах,
3. Үнэт цаасыг хадгалах журмыг зөрчих

Эрсдлийн үнэлгээний матрицыг хавсаргав.

Дотоод аудитын ажлын маягтууд, шалгах хуудсыг Төлбөр хураах цэгийн үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж асуулга авч, ярилцлага хийв. Материалыг хавсаргав.

### **Ес. Авлага, өр төлбөрийн талаар:**

**9.1 Авлага:** ТХЦ нь 2014 онд авлагын эхний үлдэгдэл 1,593.0 сая төгрөг байсан бол жилийн эцэст авлага 3,531.7 сая төгрөг болж авлага 1,938.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Жилийн эцсийн балансад авлагаар тооцсон 3,531.7 сая төгрөг нь 2013 оны орлогын үлдэгдэл болох 1,593.0 сая төгрөг, 2014 оны орлого болох 1,938.7 сая төгрөг төвлөрүүлснийг авлагаар бүртгэсэн байна.

2015 онд 2014 оны жилийн эцсийн үлдэгдэл 3,531.7 сая төгрөг дээр 2015 онд төвлөрүүлсэн нийт орлогоос батлагдсан зардлыг хассан үлдэгдэл болох 2,871.7 сая төгрөг нэмэгдэж Сангийн яамнаас татан төвлөрүүлсэн 1,938.7 сая төгрөгийг хасаад үлдэгдэл 4,464.7 сая төгрөгийг 2015 оны жилийн эцсийн авлагаар бүртгэсэн байна.

Харин Ховдын Булган сумын чиглэлд баригдах ТХЦ-ийн барилгын ажилд “Жуансу Жунжуан Жуанши” ХХК-д шилжүүлсэн 304,535.9 мянган төгрөг, Замын-Үүдийн ТХЦ-д хийгдсэн “Хүнд даацын тээврийн хэрэгслэлийг хязгаарлах зурвас, шуудуу татсан” 75.26 сая төгрөгийн төсөвтэй хөрөнгө оруулалтын ажлууд ямар ч данс бүртгэлд тусгагдаагүй орхигдсон байна.

**9.2. Өр төлбөр:** Өр төлбөр гэдэг нь өнгөрсөн хугацааны ажил гүйлгээний үр дүнд үүсч, байгууллагын нөөцөөс бусдад төлөгдөх төлбөрийн хариуцлага юм.

2014 он болон 2015 онд бусад байгуулага иргэнд өгөх өглөгийн үлдэгдэл байхгүй байна. Харин:

Шинээр баригдсан Улаанбаатар-Мандалговь чиглэлийн ТХЦ-ийн барилга байгууламжийг цахилгааны шугамаар холбох ажлыг гүйцэтгэсэн “Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК-ийн “Дундговь ЦТС салбар болон Улаанбаатар-Сайншанд чиглэлийн ТХЦ-ийн барилга байгууламжийг цахилгааны шугамаар холбох ажлыг гүйцэтгэсэн “Чингүүд” ХХК ажлыг 100 хувь өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн захиалагч ажлыг хүлээн авсан боловч санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй байтал данс бүртгэлд өр үүсгээгүй тооцооны дансанд тусгаагүй, бүртгээгүй байна. Үүнд:

"БЗӨБЦТС" ТӨХК-ий "Дундговь Цахилгаан түгээх сүлжээ" салбарт- 49,278.74 мянган төгрөг, "Чингүүд" ХХК-д -48,158.91 мянган төгрөг нийт 97,437.5 мянган төгрөгийн ажлыг хүлээн авснаар бүртгэн төлбөрийг хариуцах үүрэг хүлээн данс бүртгэлд өглөгөөр тусган шаардлагатай.

Мөн 2013-2014 онд шууд худалдан авалтын аргаар сонгон гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн Онгийн гүүрийн ТХЦ, Хархорин-Хужиртын ТХЦ, Түйн гүүрийн ТХЦ-үүдийн гадна зам, талбайн тохижилт, хурд сааруулагч, гадна 00 хийлгэсэн ажлыг 2014 онд хүлээж авсан гэх

боловч бүртгэл тайланд тусгаагүй, санхүүжилтийн 25.2 сая төгрөгийг 2015 оны 11 сард олгосон боловч бүртгээгүй данс бүртгэлд тусгаагүй байна.

Зам, тээврийн сайдын 2015 оны 180, 356 дугаар тушаалаар батлагдсан төсөл арга хэмжээний хөрөнгө оруулалтын ажил, тоног төхөөрөмж нийлүүлэх жагсаалтаар батлагдан хэрэгжсэн дээрхи ажлуудыг хөрөнгө оруулалтаар тооцон данс бүртгэлд тусгах шаардлагатай.

### **Арав. Дүгнэлт.**

1. Авто замын сан/Төлбөр хураах цэг/ нь үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж улсын авто замын санд 15 ТХЦ-ээр дамжуулан 2014 онд 2,901.5 сая төгрөг, 2015 онд 3,057.8 сая төгрөг тус тус төвлөрүүлж төлөвлөгөөг 123,0 - 105.4 хувиар биелүүлж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна.

2. Монгол Улсын Авто замын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Улсын авто замын сан нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, орон нутгийн авто замын сан нь аймаг, нийслэлийн Засаг даргын мэдэлд байна” гэж заасан боловч “хууль тогтоомжид заасны дагуу авто зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс авах төлбөр”-ийг ТХЦ-үүдээр дамжуулан хурааж Авто замын санд 100 хувь төвлөрүүлж захиран зарцуулах эрх нь Сангийн яамаар дамжигдан зарцуулагдаж иржээ.

3. Монгол Улсын Засгийн газрын “Журам батлах, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 2016 оны 103 дугаар тогтоолоор Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авах авто зам ашигласны төлбөрийн хэмжээг тээврийн хэрэслийн төрөл, ангилал, бодит жинг харгалзан төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулсныг бүх ТХЦ-үүд нэгдсэн байдлаар самбар хийж жолооч, зорчигчдод ил байршуулсан нь сайшаалтай байна.

4. Зам, тээврийн сайдын 2015.06.24-ний өдрийн 180 дугаар тушаалаар батлагдсан Авто замын сан /Төлбөр хураах цэг/-гийн 2013 оны давсан орлогоос санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд шинээр 3 төлбөр хураах цэг барих, ТХЦ-ийн тохижилт, тоног төхөөрөмж нийлүүлэх, хяналтын камер суурилуулах, пүүний орох гарах гарцыг хатуу хучилттай болгох гэх мэтийн ажил хийгдэж түүнд 1,162.1 сая төгрөгийг зарцуулсан байна. **Үүнд:** гүйцэтгэгч компанид 1,086.12 сая төгрөг, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн “ЗТХТ” ТӨҮГ-т 21,37 сая төгрөг, норм нормативын санд 1,53 сая төгрөг, баталгаат засварын барьцаанд 53,06 сая төгрөгийн санхүүжилтийг хийсэн байна.

5. Ховдын Булганы чиглэлийн замын ТХЦ-ийн барилга болон авто пүүний байр барих ажилд болон Сайншанд, Чойрын замд шинээр баригдсан ТХЦ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам холбох 2 ажил, “ӨҮ ЭЛ” ХХК-ний нийлүүлсэн тэмдэг тэмдэглэгээ, тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажлууд бүрэн дуусаагүй байхад ЗТХТ-өөс комисс ажиллуулж ашиглалтад оруулах шийдвэр гаргасан нь ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.12.3.5-д заасан “... ажлыг дутуу, чанаргүй хийсэн хууль, тогтоомж, норм, дүрмийн заалт, стандартын шаардлага зөрчсөн бол комисс ажиллахыг тодорхой хугацаагаар хойшлуулах ...” гэсэн заалтыг зөрчин ажлыг хүлээн авч санхүүжилтийг 100% олгосон байна.

6. А14 замын Ховдын Булганы чиглэлд ТХЦ-ийн барилга болон авто пүүний байр, замын байгууламж барихаар гэрээ байгуулсан “Жиансу Жунжиан Жианши” ХХК нь Төлбөр

хураах цэг, авто пүүний байр барих талбай гаргаж 150 тонны даац бүхий пүү байрлуулсан боловч холбогдох байр, барилга байгууламж баригдаагүй байх үед захиалагч “ЗТХТ” ТӨҮГ-ын захирлын 2015.11.26-ны өдрийн 230 дугаар тушаалаар “ажил хүлээн авах комисс” томилон ажлуулж уг комиссоос ТХЦ-ийн барилгын ажил дууссан тухай акт үйлдэн санхүүжилтийг 100 хувь олгох шийдвэр гарган 304,535.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон ба энэхүү олгосон мөнгийг Нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгээгүй, гэрээний үүргийн биелэлтийг тус компанитай тооцоогүй байна.

7. Шинээр баригдсан А0201 дугаартай Улаанбаатар-Мандалговь чиглэлийн ТХЦ-т цахилгааны шугамаар холбох ажлыг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн Дундговь цахилгаан түгээх салбар, А0102 дугаартай Улаанбаатар-Сайншанд чиглэлд ТХЦ-ийн барилгыг цахилгаан шугамаар холбох ажлыг “Чингүүд” ХХК-тай гэрээ байгуулснаар гүйцэтгэгч компаниуд 100% өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн захиалагч ЗТХТ ажлыг хүлээн авсан боловч санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй байтал данс бүртгэлд өглөгөөр бүртгээгүй байна. Үүнд:

8. 2013 оны давсан орлогоос санхүүжсэн хөрөнгө оруулалтын зарим ажлуудыг данс бүртгэлд тусгаагүй байна. Үүнд: “Жиансу Жунжиан Жианши” ХХК-иас гэрээний дагуу нийлүүлэх ажил хийгээгүй байхад олгосон 304.53 сая төгрөг, Зам-Үүд ТХЦ-т хийгдсэн “Хүнд даацын тээврийн хэрэгслэлийг хязгаарлах зурвас, шуудуу татах” 75.24 сая төгрөг, нийт 397.77 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна.

#### **Арван нэг. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж**

1. ТХЦ-үүдээс оруулах орлогыг тухайн зам гүүрэн дээр авто машины эрчмийн тооллого хийсний үндсэн дээр орлогыг төлөвлөх, оруулсан орлого, орон тоотой уялдуулан төсвийн зардлыг батлах,

2. Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдсан Улаанбаатар-Мандалговь, Улаанбаатар-Сайншанд чиглэлийн ТХЦ-үүдийн барилга байгууламжуудыг 2015 оны 11 сард ашиглалтанд хүлээж авсан боловч ажил нь эхлээгүй өмч хөрөнгө эзэнгүйдэж байгаад анхаарч тус цэгүүдийн орон тоо, зардлыг 2016 оны төсөвийн тодотголд яаралтай тусгуулж үйл ажиллагааг нь эхлүүлэх;

3. Ховдын Булганы чиглэлийн ТХЦ-ийн болон авто пүүний барилга, замын байгууламж барих ажлын тендерт шалгарч ажлаа цаг хугацаанд нь хийгээгүй, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй “Жиансу Жунжиан Жианши” ХХК-тэй хийсэн гэрээг дүгнэж, гэрээний үүргийг хангуулах, “Жиансу Жунжиан Жианши” ХХК-д олгосон 308.45 сая төгрөгийг данс бүртгэлд тусгаж хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлж үргүй зардал гаргахгүй байх;

4. “ӨҮ ЭЛ” ХХК-ий нийлүүлсэн ашиглалтын шаардлага хангахгүй байгаа техник тоног төхөөрөмжийг засварлах, шинэчлэх ажлыг баталгаат хугацаанд нь гүйцэтгүүлэх;

5. Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажилд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах, ажлыг хүлээж авахаас өмнө хяналтын инженерийн тайланг хэлэлцэж комисс ажиллуулах шийдвэр гаргах болон гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж байх, хяналтын инженерүүдийн ажлыг эрчимжүүлэх;

6. ТХЦ дээр ашиглаж байгаа үнэт цаас /тасалбар/-ны бүртгэл, тооцоо, хүлээлцэх баримтыг нэг загварт оруулах, маягт болон ээлжийн ажлын тайлан бичих загвар боловсруулж батлуулах, ТХЦ-үүдийг үнэт цаас /тасалбар/-ыг хадгалах сейфтэй болгох.

**7.** Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх хууль, эрх зүйн актуудыг гарын доор, өдөр тутам ашиглаж болох хэлбэрээр ТХЦ дээр байршуулах.

**8.** Үнэт цаас /тасалбар/-ын тайлан тооцоог ТХЦ-ийг хариуцсан албаны дарга баталгаажуулж, гарын үсэг зурж байх.

**9.** Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тэврийн хэрэгслээс авсан төлбөрийн орлогыг өдөрт нь тушааж байхаар журамлах.

**10.** Замын-Үүдийн хил дээрх ашиглагддаггүй пүүг балансаас баланс руу шилжүүлэн авч ТХЦ дээр байршуулах асуудлыг орон нутгийн захиргаа, хилийн бүсэд байгаа татвар, гаалийн байгууллагуудтай хамтран яаралтай шийдвэрлэх.

**11.** Зам, тэврийн сайдаас Аймгийн Засаг дарга нар, “АТҮТ” ТӨҮГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээнд ТХЦ-ийн үйл ажиллагааг дэмжиж, хяналтын болон бусад чиглэлээр хамтран ажиллах заалтуудыг оруулах.

**12.** “ЗТХТ” ТӨҮГ-т харьяалагдах боловч үйл ажиллагааны статус нь өөр Төлбөр хураах цэгийг бие даасан улсын төсөвт аж ахуйн нэгж болгон зохион байгуулах эрх зүйн орчинг судлан, санал боловсруулж хэлэлцүүлэх.

**13.** Шилэн дансны програмыг засаж, ажиллуулах асуудлыг яаралтай шийдвэрлэж өгөх талаар Сангийн яаманд албан бичгээр хандаж, асуудлыг яаралтай шийдвэрлүүлэх.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**